



ШҮҮХИЙН АКАДЕМИ

**“ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛЫН
ГЭРЭЭНИЙ ШААРДАХ ЭРХ ИРГЭНИЙ
ХУУЛИЙН 443.7-Д ЗААСНЫ ДАГУУ
ШИЛЖИХ ЭСЭХ, ЭНЭ ЗОХИЦУУЛАЛТЫГ
497.1-ТЭЙ УЯЛДУУЛАН ТАЙЛБАРЛАХ
АСУУДАЛ”-ТАЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН
ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2024.09.24**

“ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ШААРДАХ ЭРХ ИРГЭНИЙ ХУУЛИЙН 443.7-Д ЗААСНЫ ДАГУУ ШИЛЖИХ ЭСЭХ, ЭНЭ ЗОХИЦУУЛАЛТЫГ 497.1-ТЭЙ УЯЛДУУЛАН ТАЙЛБАРЛАХ АСУУДАЛ”-ТАЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ¹

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024.06.04

Шүүхийн шийдвэрийн дугаар: УДШ-ийн 001/ХТ2024/00126²

Шүүхийн шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан.

НЭГ. ХЭРГИЙН ҮЙЛ БАРИМТ

Нэхэмжлэгч “М Д” ХК нь хариуцагч Ж.Э-д холбогдуулан шилжүүлэн авсан шаардах эрхийн дагуу 56,918,027 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан. “... “М Д” ХК нь Д.М, Б.Г нартай 2015.06.19-ний өдөр орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн даатгалын гэрээ байгуулсан ба 2015.10.19-ны шөнө болсон зам тээврийн ослын улмаас Д.М-ийн амь нас хохирч даатгалын тохиолдол үүссэн.

Хэргийн маргааны зүйл нь даатгагчаас эрх бүхий этгээдэд төлсөн даатгалын нөхөн төлбөрийг даатгалын эрсдэл бий болгоход нөлөөлсөн гэм буруутай этгээд болох Ж.Э-ээс шаардан гаргуулах үндэслэлтэй эсэх асуудал юм. Даатгагч Иргэний хуулийн 443 дугаар зүйлийн 443.7-д заасны дагуу болон Б.Г-аас шаардах эрхээ шилжүүлэх хэлцлийн дагуу гэм буруутай этгээдээс хохирол шаардах эрхийг “М Д” ХК шилжүүлэн авсан гэж маргаж байгаа бол хариуцагч шилжүүлэн авсан уг шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, банкны зээлийн төлбөрийг төлсөн тул “М Д” ХК өөрт учирсан хохирлоо Ж.Э-оос шаардах эрхгүй гэж тайлбарлаж маргасан.

ХОЁР. ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Анхан шатны шүүх: “... Д.М болон “М Д” ХК хоёрын хооронд эрсдэлийн даатгалын эрх зүйн харилцаа үүссэн гэж үзэх хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй. Хариуцагч Ж.Э нь хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэх шалтгаанаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь зөвшөөрөхгүй гэж мэтгэлцсэн боловч “М Д” ХК болон Д.М нарын хооронд эрх зүйн харилцаа үүсээгүй байх тул хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн эсэх дээр хууль зүйн дүгнэлт өгөх боломжгүй...хэмээн хариуцагч Ж.Э-д холбогдох шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх: Нэхэмжлэгч “М Д” ХК даатгуулагчийн банкны зээлийн төлбөрийг төлсөн тул “М Д” ХК өөрт учирсан хохирлоо хариуцагч Ж.Э-ээс шаардах эрх шилжсэн гэж үзнэ. Даатгагч гэм хорыг даатгуулагчид нөхөн төлснөөр шаардах эрх даатгагчид шилжинэ гэсэн нь нэхэмжлэгч “М Д” ХК-ийн нэхэмжлэлийн шаардлагад нийцсэн ба Иргэний хууль (ИХ)-ийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар хариуцагч Ж.Э нь “М Д” ХК-д учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

¹ Энэхүү дүн шинжилгээг Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн удирдаж, Иргэний эрх зүйн секторын эрхлэгч А.Нэмүүлэн хийж гүйцэтгэсэн болно.

² Шүүхийн шийдвэрийг дэлгэрэнгүй үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/10563?daterange=2024-01-01%20-%202024-08-14&id=3&court_cat=1&bb=1

Даатгуулагч Д.М-ийн хууль ёсны өв залгамжлагч Б.Г шаардах эрхээ “М Д” ХК-д 2017.02.22-ны өдөр шилжүүлсэн нь нэхэмжлэх эрх шилжүүлэх хэлцлээр тогтоогдож байна. ИХ-ийн 75 дугаар зүйлийн 75.1, 75.2.4-д заасан ерөнхий болон тусгай хугацаа тус тус хэтрээгүй буюу шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааны дотор байх тул анхан шатны шүүх хөөн хэлэлцэх хугацааны талаар хууль зүйн дүгнэлт өгөх боломжгүй гэж үндэслэлээ огт тайлбарлаагүй нь үндэслэлгүй, ойлгомжгүй болсон...” гэж дүгнэж, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

Хяналтын шатны шүүх: Хоёр шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ баримталсан хуулийн заалт зөрүүтэйн зэрэгцээ хэргийг шийдвэрлэхэд үндэслэл болгосон ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7, 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг ялгаатай байдлаар тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж хяналтын журмаар хэлэлцсэн байна. Дээд шүүхээс тус маргааныг шийдвэрлэхэд “М Д” ХК-д шаардах эрх бий эсэхийг эхлэн тодорхойлох нь зүйтэй хэмээн үзэж, дараах байдлаар тайлбарласан байна.

1. “М Д” ХК хохирогчийн банктай байгуулсан зээлийн гэрээний үлдэгдэл төлбөрийг эрсдэлийн даатгалын хүрээнд нөхөн төлсөн байна. Тодруулбал, даатгуулагч өөрийн амь нас хохирсон үед түүний банктай байгуулсан зээлийн өрийн үлдэгдлийг даатгагч түүний өмнөөс төлж барагдуулахаар даатгалын гэрээ байгуулсныг даатгагч маргаагүй бөгөөд тус гэрээнд заасан даатгалын тохиолдол бий болж эрсдэл учирсан тул зээлийн үлдэгдэл төлбөр 56,847,827 төгрөгийг төлсөн.

Дээрх даатгалын гэрээ нь гэм хорын болон амь насны даатгалын төрөлд хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл зээлдэгч нас барж, түүний бусдад өгөх зээл төлөгдөхгүй болох эрсдэл нь гэм хорын төрөл биш, харин зээлийн гэрээний үүрэг биелэгдэхгүй байх эрсдэл гэж үзнэ. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барснаар гэм буруутай этгээдээс шаардан нэхэмжлэх гэм хорын төрөлд хохирогчийн бусадтай байгуулсан зээлийн гэрээний төлөгдөөгүй үлдэгдэл хамаарахгүй. (14)³

2. ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7 дахь хэсэг нь даатгагч даатгалын нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардан гаргуулах эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авах зохицуулалт мөн хэдий ч **ийнхүү шилжүүлэн авах шаардах эрх нь гэм хорын эрх зүйн шаардах эрхтэй байх учиртай.** (14)

Тодруулбал, ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7-д “Даатгуулагч учирсан гэм хорыг нөхөн төлөх шаардлагыг гуравдагч этгээдэд гаргаж болох тохиолдолд ...” шаардах эрх түүнд шилжихээр зохицуулснаас үзвэл **энэ зүйл заалтын дагуу шаардах эрх шилжихийн тулд даатгуулагч, түүнд учирсан гэм хорыг буруутай этгээдээс шаардах эрхтэй байх урьдчилсан нөхцөл тавигджээ.**

Гэтэл зээлийн эрсдэлийн даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авсан Б.Ганзулд ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт заасны дагуу хохирогч Д.М-ийн

³ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

банктай байгуулсан зээлийн гэрээний үлдэгдэл төлбөрийг хариуцагч Ж.Э-оос шаардах эрх байхгүй. Өөрт үүсээгүй шаардах эрхийг бусдад шилжүүлэх боломжгүй. (14)

3. Дээрх үндэслэлээр хяналтын шатны шүүх зээлийн эрсдэлийн даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авсан Б.Г-д үүсээгүй шаардах эрхийг “М Д” ХК хүлээн авсан байх боломжгүй тул нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.(15) ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7 дахь заалт нь шаардах эрх даатгалын компанид хуулийн дагуу шилжих зохицуулалт тул шаардах эрхийг шилжүүлсэн хэлцлийн хүчин төгөлдөр байдал, уг хэлцэлтэй холбоотой асуудлаар тусгайлан дүгнэлт өгөх шаардлагагүй.(16)

Дээр дурдсан үндэслэлээр нэхэмжлэгч ба түүний өмгөөлөгчийн хууль хэрэглээний зөрүүг арилгах тухай гомдлыг хангаж анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дээрх хяналтын шатны шүүхийн тогтоол нь зээлийн эрсдэлийн даатгалын гэрээний шаардах эрхтэй холбоотой асуудлыг хөндсөн бөгөөд уг асуудалд хамаарах онол, шүүхийн практик болон харьцуулсан судалгааг хийсний үндсэн дээр , УДШ-ийн 2024 оны 06 сарын 04-ны өдрийн 001/ХТ2024/00126 тогтоолд дүгнэлт өгөх болно.

3.1. Эрх зүйн зохицуулалт, онолын ойлголт

Зээлийн эрсдэлийн даатгалын гэрээний талаар нарийвчлан авч үзэхээс өмнө гэрээний үүрэг болон гэрээний бус үүргийн талаарх ойлголт, холбогдох эрх зүйн зохицуулалтыг авч үзэх нь зүйтэй. Үүнд:

Гэрээний үүрэг нь талуудын зөвшилцөл, итгэлцэл дээр үндэслэн бий болдог⁴ бол гэрээний бус үүргийн харилцаа хуульд тухайлан заасан нөхцөл бүрэлдсэнээр талуудын хооронд үүсдэг бөгөөд гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран буруутай этгээдэд шаардлага гаргаж болдог. Өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн харилцааны гэрээний үндсэн дээр үүсэх үүргийг гэрээний бус үүргээс ялгаж үзэх нь гэрээнээс үүсэх хууль зүйн үр дагаврыг ойлгоход чухал ач холбогдолтой болно.⁵

Хэргийн нөхцөлийг ерөнхийд нь авч үзвэл даатгалд хамаарах гэрээний болон гэрээний бус үүрэг, тэдгээрт үүсэх үр дагаврын ялгаатай байдлыг хөндсөн байна. Гэрээний үүргийн зөрчлийн хувьд талууд гэрээний эрх зүйн үндсэн зарчим болох “гэрээний үүргийг заавал биелүүлэх” зарчмыг баримталдаг ба хэрэв гэрээний үүргийг биелүүлээгүй тохиолдолд энэхүү зөрчил нь хууль зүйн үр дагавар үүсгэх үндэслэл болдог.⁶

⁴ Иргэний хууль (2002)-ийн 13 дугаар зүйлийн 13.1.

⁵ Ж.Оюунтунгалаг, *Иргэний эрх зүй II, Гэрээний үүрэг*, 2022, 16-17 дахь тал.

⁶ Мөн тэнд, 84 дэх тал.

Түүнчлэн гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь зөрчлийн улмаас үүсэх үүрэгт хамаардаг. Энэ талаарх ойлголт нь ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-дэх хэсэгт агуулагддаг ба үүнийг гэм хорын хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсэн хэм хэмжээ гэж үздэг. Гэм хорын хариуцлага хүлээлгэх үндэслэлийг эрдэмтэд гэм хор учруулагчийн хууль бус үйлдэл, хохирол, үйлдэл ба хохирлын хоорондын шалтгаант холбоо, гэм хор учруулагчийн гэм буруу гэж үздэг.

Гэм хорын хариуцлага хүлээлгэхэд зөрчил үйлдсэн объектын хувьд бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгө байх бөгөөд гэм хор учруулагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гэм хор учирсан байх, үйлдэл /эс үйлдэхүй/ болон учирсан хохирлын хооронд шалтгаант холбоотой байх, зөрчил үйлдэгч гэм буруутай /санаатай, болгоомжгүй/ байхыг хуулиар тогтоосон.⁷ Өөрөөр хэлбэл тухайн гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдын хуулиар хамгаалагдсан эрх зөрчигдөн улмаар энэ нь гэм хорын хохирол болдог тул уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй юм.⁸

Харин даатгал хийлгэх гэдэгт даатгуулагчид тохиож болох эрсдэлийг гэрээний тохиролцооны үндсэн дээр даатгагчид шилжүүлнэ гэсэн үг. Гагцхүү нэг тал нь тодорхой аюул ослоос сэргийлэх амлалтыг даатгал биш хэмээн ойлгодог.⁹ Мөн даатгалтай холбоотой хэлцлийн эдийн засгийн үндэс нь аливаа этгээдэд бий болж болох эрсдэлийг тодорхой хэсэг бүлэг этгээдийн нэгдэлд урьдчилан шилжүүлэх замаар уг эрсдэлээс урьдчилан сэргийлэх явдал хэмээн тодорхойлсон байдаг.¹⁰

Даатгалын эрх зүйн харилцаа нь даатгалын зүйлээсээ хамааран өөр өөр байх бөгөөд даатгалыг гэрээний объектоор, хамгаалах эрсдэлээр нь гэх мэтчилэн тодорхой шалгуураар ангилж нь илүү тохиромжтой байна хэмээн үздэг.¹¹ Гэхдээ Монгол Улсад даатгалыг албан журмын болон сайн дурын гэж ангилдаг бөгөөд сайн дурын даатгалд санхүүгийн даатгал багтдаг учир үүнд зээлийн эрсдэлийн даатгал хамаарах боломжтой юм.¹²

Даатгалын эрх зүйн харилцааны хүрээнд хөндөгдөж буй ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7-д зохицуулалт нь даатгалд хэрэглэдэг суброгаци (subrogation) буюу төлбөр нэхэмжлэх эрх шилжүүлэлтийн ойлголтыг агуулдаг бөгөөд олон улсын хэмжээнд зарчмын үүднээс авч үздэг. Энэ нь улс төрийн эрсдэлээс хамгаалж гадаадын хөрөнгө оруулалтын олон улсын даатгалд хэрэглэдэг¹³ онцлогтой. Тус зарчим нь Монгол Улсад даатгалын үндсэн зарчимд хамаардаг ба мөн адил суброгацийн зарчим (subrogation) хэмээн нэрлэгддэг.

⁷ Монгол Улсын Дээд шүүх, *Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Гэрээний бус үүрэг IV*, 2016, 53-54 дэх тал.

⁸ Мөн тэнд, 55 дахь тал.

⁹ Мөн тэнд, 316 дахь тал.

¹⁰ Б.Буянхшиг, *"Иргэний эрх зүйн тусгай анги: гэрээний эрх зүй"*, 5 дах хэвлэл, 2019, 310 дахь тал.

¹¹ Мөн тэнд, 322 дахь тал.

¹² Монгол банк, *Санхүүгийн боловсрол, даатгал, түүний төрлүүд*.

<https://www.sankhuugiiinbolovsrol.mn/cdn/pdf/Huvi%20hun%20buleg14.pdf> (Сүүлд үзсэн: 2024.08.26)

¹³ Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан, *Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын үүсэл хөгжил, хэтийн төлөв судалгаа*, 677 дахь тал, https://nli.gov.mn/pdf/gadaadiin_hurungu_oruulaltiin.pdf (Сүүлд үзсэн: 2024.09.04)

Даатгуулагчийн эд хөрөнгө, амь насанд эрсдэл учирсан явдалд гуравдагч этгээд буруутай бол даатгуулагчийн хохирлыг түргэн шуурхай барагдуулах ба гаргасан нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарах зардлын нийлбэрээр буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх зарчим болж үйлчилдэг.¹⁴

Иймд дээрх онолын ойлголтуудаас үзвэл ИХ-ийн 497.1-д гэрээний бус үүргээс үүсэх зөрчлийн үндсэн объектуудыг зохицуулсан бол ИХ-ийн 443.7 нь гэрээний бус үүргээс үүдэлтэй хохирол учирсан тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг шаардах эрхийг шилжүүлэн авахтай холбоотой даатгалын эрх зүйн асуудлыг хөндсөн зохицуулалт байна. Өөрөөр хэлбэл энэхүү хоёр зохицуулалт нь гэрээний бус үүргийн харилцаанд хэрэглэгдэх зохицуулалт байх бөгөөд даатгагч нь даатгуулагчийн хохиролд буруутай этгээдийн эсрэг хэрэгжүүлж болох гэм хорын шаардах эрх (ИХ-ийн 497.1) нь хуулийн (ИХ-ийн 443.7) дагуу шилжихээр¹⁵ байна.

Даатгалын төрөл бүр нь талуудын хоорондын эрх зүйн харилцаа, байгуулсан гэрээ, хэлцлийн төрлөөсөө хамаараад ялгаатай байна. Зээлийн эрсдэлийн даатгалын хувьд зээлдэгч зээл төлөх үүргээ зөрчсөн тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг гэрээнд заасны дагуу төлүүлэх шаардах эрх үүсэж байх тул гэрээний үүргийн дагуу шаардах эрх бий болох харилцаа хэмээн үзэж болох юм.¹⁶

3.2. Төсөөтэй шүүхийн шийдвэр

Энэхүү хэсэгт ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7 болон 497 дүгээр зүйлийн 497.1-дэх хэсгийг хэрэглэж, эдгээр зүйл, заалтын уялдаа холбоог тайлбарласан шүүхийн шийдвэр цөөн олдсон тул даатгалын гэрээний төрлүүдийн шаардах эрх ялгаатай болохыг тодотгох үүднээс зээлийн эрсдэлийн даатгалын гэрээнээс өөр даатгалын эрх зүйн харилцааны хүрээнд дээрх зүйл заалтуудыг тайлбарлан хэрэглэсэн хяналтын шатны шүүхийн 1 тогтоолыг сонгон авч, харьцуулсан дүн шинжилгээ хийв.

Уг тогтоол нь дүн шинжилгээ хийж буй үндсэн тогтоолын адил даатгалын эрх зүйн харилцааг хөндөн, ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7 болон 497 дүгээр зүйлийн 497.1-дэх хэсгийг хэрэглэсэн байх тул сонгон авсан болно.

2018 оны 04 дүгээр сарын 13-ы өдрийн УДШ-ийн 001/ХТ2018/00604¹⁷-ийн шийдвэр:

Хэргийн үйл баримт: Нэхэмжлэгч “М” ХХК нь Д.Г-д холбогдуулан даатгуулагчийн эд хөрөнгөд гэм хор учруулсны нөхөн төлбөрт төлсөн 2,786,260 төгрөгийг гаргуулахаар нэхэмжлэл гаргасныг хариуцагч эс зөвшөөрч, зам тээврийн осол гарахад би буруугүй, түүнчлэн осол гарахад автомашиныг жолоодож явсан хүмүүс нь даатгалын гэрээ хийгээгүй байсан тул нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй гэж маргасан.

Үйл баримтын хувьд тодруулбал, 2015 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр зам тээврийн осол гарч, хариуцагч Д.Г нь 66-94 УБЕ дугаарын Ниссан пулсар маркийн автомашиныг жолоодож

¹⁴ Санхүүгийн зохицуулах хороо, *Үл хөдлөх эд хөрөнгийн даатгалын гарын авлага*, 2014, 5 дахь тал, <https://www.frc.mn/resource/frc/uploads/page/1fd58a2b6e550d66e17978e118122b927587053c.pdf> (Сүүлд үзсэн: 2024.09.04)

¹⁵ Б.Буянхишиг, *мөн тэнд*, 333 дахь тал.

¹⁶ Монгол даатгал, *Зээлийн эрсдэлийн даатгал*, https://www.mongoldaatgal.mn/?page_id=6642 (Сүүлд үзсэн: 2024.09.05)

¹⁷ Шүүхийн шийдвэрийг дэлгэрэнгүй үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/4145?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1

явахдаа Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөнөөс даатгуулагч Х.Бат-Эрдэнийн өмчлөлийн 02-16 УНГ автомашин, даатгуулагч Х.Баянжаргалын өмчлөлийн 26-95 УНУ дугаарын автомашинуудыг мөргөж, хохирол учруулсан гэж үзэж “М” ХХК даатгуулагч нарт учирсан хохирол 2,786,260 төгрөгийг төлсөн, уг хохирлоо буруутай этгээд Д.Г-с гаргуулахаар нэхэмжилсэн үйл баримт тогтоогдсон байна.

Шийдвэрлэсэн байдал, үндэслэл: Анхан шатны шүүхээс ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.1¹⁸, 443.7¹⁹-д зааснаар нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүхээс Хуулийн зүйлчлэлийг ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1²⁰, 510 дугаар зүйлийн 510.1²¹ болгон, бусад заалтыг хэвээр үлдээн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс Давж заалдах шатны шүүх нэхэмжлэгчийг ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан гэм хорын хохирлыг шаардсан гэж үзэн анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулсан нь нэхэмжлэлийн шаардлага, хэргийн үйл баримттай нийцээгүй байна. Үүнд:

ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх заалт нь **гэрээний бус үүрэгтэй холбоотой зохицуулалт** бөгөөд бусдын эд хөрөнгө, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндэд гэм хор учруулсан этгээд хохирсон этгээдэд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээдэг. Хохирогчид учирсан хохирол нь гэм хор учруулсан этгээдийн санаатай болон болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйтэй шалтгаант холбоотой байдаг тул уг хохирсон этгээд учирсан гэм хорыг арилгуулахаар шаардах эрхтэй.

Харин нэхэмжлэгч “М” ХХК нь Даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн гэж даатгуулагчид төлсөн нөхөн төлбөрөө гэм хор учруулсан этгээдээс шаардсан байх бөгөөд түүний шаардах эрх нь даатгалын гэрээ, хуулиар үүссэн агуулгатай байхад давж заалдах шатны шүүх хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна. **Мөн даатгуулагч Х.Бат-Эрдэнэ, Х.Баянжаргал нартай байгуулсан эд хөрөнгийн даатгалын гэрээний дагуу даатгалын тохиолдол бий болсон бол “Мандал женерал даатгал” ХХК даатгуулагчид төлсөн гэм хорын хохирлыг гуравдагч этгээдээс шаардах эрхийг “М” ХХК хэрэгжүүлэх эрхтэй байна.**

Даатгагч гэм хорыг даатгуулагчид нөхөн төлснөөр шаардах эрх даатгагчид шилжинэ гэсэн зохицуулалт нь зөвхөн гэм хорыг төлснөөр хязгаарлагдахгүй, уг гэм хорыг төлөх үндэслэл байгаа эсэх нөхцөл тогтоогдсон байхыг шаардах ба талуудад авагдсан “Мандал Женерал даатгал” ХХК-ийн А.Б, Х.Б нартай байгуулсан Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн даатгалын гэрээнд даатгалын зүйл болох автотээвэр өөрөө явагч хэрэгслийн марк, улсын дугаар бичигдээгүй байх тул осолд орсон тээврийн хэрэгсэл хэдийгээр даатгуулагч нарын өмчлөлийн эд хөрөнгө мөн боловч даатгуулсан эд хөрөнгө буюу даатгалын зүйл мөн эсэх нь тодорхойгүй байна.

Түүнчлэн гэрээний 8.2.1-д “Даатгалын гэрээ болон баталгаанд нэр заасан эрх бүхий жолоочоос бусад этгээд, мөн жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгслийг ашиглаж, хэрэглэх үед учирсан хохиролд даатгагч нөхөн төлбөр олгохгүй” гэжээ. Зам тээврийн осол болох үед даатгуулагч Х.Бат-Эрдэнийн өмчлөлийн авто машиныг Л.Мөнгөнцэцэг, даатгуулагч Х.Баянжаргалын өмчлөлийн автомашиныг Э.Анхбаяр нар тус тус жолоодож явсан, тэдгээр нь

¹⁸ Иргэний хууль (2002)-ийн 443 дугаар зүйлийн 443.1-д “Гэм хорын даатгалаар даатгагч нь даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхолд учирсан гэм хорыг даатгалын үнэлгээний хэмжээгээр мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх үүрэг хүлээнэ.”

¹⁹ ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7-д “Даатгуулагч учирсан гэм хорыг нөхөн төлөх шаардлагыг гуравдагч этгээдэд гаргаж болох тохиолдолд даатгагч уг гэм хорыг даатгуулагчид нөхөн төлснөөр шаардах эрх даатгагчид шилжинэ. Харин даатгуулагч гуравдагч этгээдэд шаардлага гаргах буюу шаардлагыг хангуулах эрхээсээ татгалзсан бол тэр хэмжээгээр даатгагч гэм хорыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөгдөнө.”

²⁰ ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-д “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.”

²¹ ИХ-ийн 510 дугаар зүйлийн 510.1-д “Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх /адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, эмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/ буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө.”

даатгалын гэрээний оролцогч биш тул гэрээнд заасан даатгалын нөхөн төлбөр олгохгүй нөхцөл байдалд хамаарахаар байна.

Анхан шатны шүүх талуудын хооронд үүссэн даатгалын гэрээний эрх зүйн харилцааг зөв тодорхойлж ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.1, 443 дугаар зүйлийн 443.7 дахь заалтыг зөв тайлбарлаж хэрэглэсэн байх тул шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна хэмээн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээн шийдвэрлэсэн болно.

Дээрхээс дүгнэн үзвэл шүүхийн шийдвэрийн гол маргааны зүйл нь “даатгагчаас эрх бүхий этгээдэд төлсөн даатгалын нөхөн төлбөрийг даатгалын эрсдэл бий болгоход нөлөөлсөн гэм буруутай гуравдагч этгээдээс шаардан гаргуулах үндэслэлтэй эсэх”-тэй холбоотой байна. Харин хууль хэрэглээний хувьд ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7 дэх хэсэг (тус зүйл, заалтыг ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгтэй уялдуулан тайлбарлах) нь **гэм хорын даатгалын тохиолдолд хэрэглэдэг эрх зүйн зохицуулалт байгаа нь** дээрх шийдвэрээр харагдаж байна.

Хяналтын шатны шүүхээс²² “даатгалын гэрээ нь гэм хорын болон амь насны даатгалын төрөлд хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл зээлдэгч нас барж, түүний бусдад өгөх зээл төлөгдөхгүй болох эрсдэл нь гэм хорын төрөл биш, харин зээлийн гэрээний үүрэг биелэгдэхгүй байх эрсдэл гэж үзнэ. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барснаар гэм буруутай этгээдээс шаардан нэхэмжлэх гэм хорын төрөлд хохирогчийн бусадтай байгуулсан зээлийн гэрээний төлөгдөөгүй үлдэгдэл хамаарахгүй” хэмээн тайлбарлаж, мөн зээлийн эрсдэлийн даатгалд зээлийн гэрээний үүрэг биелэгдэхгүй байх эрсдэл нь даатгалын зүйлд хамаарна гэж үзсэн.

Харин талуудын хоорондын харилцаа нь гэрээний үүргийн үндсэн дээр явагдаж байх учир гэрээний үүргийн бус харилцаа болох түүний үр дагаварт үүсэх гэм хор, хохирлыг авч үзэх үндэслэл үүсэх боломжгүй гэсэн байр суурийг төсөөтэй шүүхийн шийдвэрээр мөн адил илэрхийлсэн байна.

Хяналтын шатны шүүхээс ИХ-ийн 443.7 дэх зүйлийг “даатгагч даатгалын нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардан гаргуулах эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авах зохицуулалт мөн боловч “...учирсан гэм хорыг буруутай этгээдээс шаардах эрхтэй байх урьдчилсан нөхцөл тавигджээ...”, “...шилжүүлэн авах шаардах эрх нь гэм хорын эрх зүйн шаардах эрхтэй байх учиртай...” гэж тус тус тайлбарлан хэрэглэсэн байгаа нь төсөөтэй шүүхийн шийдвэртэй мөн адил агуулгатай байна. Тодруулбал, төсөөтэй шүүхийн шийдвэрт “зээлийн эрсдэлийн даатгалтай холбоотой бус эд хөрөнгийн даатгалын гэрээтэй холбоотой хэдий ч ИХ-ийн 497.1 дэх зүйлийг “гэрээний бус үүрэгтэй холбоотой зохицуулалт” болох гэм хорын эрх зүйн шаардах эрх бий болох” талаар тодотгож тайлбарласан.

Даатгагч нь даатгуулагчийн хохиролд буруутай этгээдийн эсрэг хэрэгжүүлж болох гэм хорын шаардах эрх (ИХ-ийн 497.1) нь хуулийн (ИХ-ийн 443.7) дагуу шилжихээр байна. Иймд, эдгээр зохицуулалтууд нь гэрээний бус, гэм хорын даатгалын төрөлд хамаарна гэсэн дүгнэлтүүдийг тус тус хийсэн байна.

²² УДШ-ийн 001/ХТ2024/00126 дугаартай хяналтын шатны шүүхийн тогтоол.

3.3. Харьцуулсан судалгаа

Дүн шинжилгээний энэхүү хэсэгт бусад улс орнуудад даатгалын эрх зүйн харилцаа, түүний төрөл болох зээлийн эрсдэлийн даатгалд ямар тохиолдлууд хамаардаг, мөн даатгалын эрсдэлийг гуравдагч этгээд бий болгосон тохиолдолд холбогдох үр дагаврыг хэрхэн зохицуулдаг болохыг авч үзэхээр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс /Англи Улс/ болон Япон улсыг сонгон авч судалсан болно.

Эдгээр улсыг сонгон авсан үндэслэлийн хувьд нэгдүгээрт даатгалын эрх зүйн харилцаа нь Англи улсаас гаралтай бөгөөд даатгалын эрх зүйд хамаарах онолын ойлголт нь өргөн хүрээнд, нарийвчлан судлагдсан байдаг. Хоёрдугаарт Япон улсын хувьд Монгол Улсын адил эх газрын эрх зүйн тогтолцоотой орнууд дундаа даатгалын эрх зүйн харилцааг нарийвчилсан цогц байдлаар зохицуулсан байдаг тул тус 2 улсыг сонгосон болно.

3.3.1. ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС (АНГЛИ УЛС-ИБУИНХУ)

Зээлийн эрсдэлийн даатгалын тухайд:

Тус улсын хувьд зээлийн эрсдэлийн даатгал (Credit risk insurance)-д “Худалдааны зээлийн даатгал буюу олон улсын түвшинд хэрэглэгддэг даатгал (Trade credit insurance), мөн зээлийн даатгал (Credit Insurance)” хамаардаг. Нэр томъёоны хувьд болон хамрах хүрээ нь ялгаатай хэдий ч дээр дурдсан даатгал нь агуулгын хувьд зээлийн гэрээний үүрэг биелэгдээгүй байх эрсдэл үүссэн тохиолдлыг даатгалын нөхцөл үүссэн хэмээн үздэг. Тодруулбал:

Зээлийн даатгал нь зээлийн гэрээний төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлээс хамгаалах даатгал хэмээн ойлгож болно.²³ Уг даатгалын эрсдэлийг зээлийн эрсдэл болон улс төрийн эрсдэл гэж хоёр байдлаар ангилдаг. Зээлийн эрсдэлийн даатгал нь үйл ажиллагаа буюу бизнес эрхлэгчид болон хувь хүмүүст зориулсан муу зээлдэгч болохоос эсхүл харилцагчийн төлбөрийн чадваргүй байдлын нөлөөллөөс хамгаалдаг даатгал²⁴ бөгөөд талууд 1-т төлбөрийн чадваргүй болох, 2-т гэрээний үүргээ биелүүлээгүй байх гэсэн даатгалын эрсдэлийн хоёр урьдчилсан нөхцөлийг зааж даатгалын гэрээг байгуулдаг.²⁵

“Subrogation буюу нөхөн төлбөр нэхэмжлэх эрх шилжүүлэлт” болон гуравдагч этгээдийн хариуцлагын тухайд:

Зээлийн эрсдэлийн даатгалд даатгагч болон даатгуулагч нараас гадна гуравдагч этгээд оролцсон тохиолдол буюу гуравдагч этгээд нь даатгуулагчид гэм

²³James Larkin, Credit Insurance-An Introduction (1995), 17.

<https://bila.org.uk/wp-content/uploads/old/4ff4163fdbaa93.57092984.pdf> (Сүүлд үзсэн: 2024.08.15)

²⁴Aon Credit International (ACI), Introduction to Credit Insurance (2016), 5,

<https://www.aon.com/unitedkingdom/products-and-services/risk-services/attachments/aci/aci-introduction-credit-insurance.pdf> (Сүүлд үзсэн: 2024.08.15)

²⁵ *Ibid*, 19.

хор учруулсан бол даатгалын тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг онолын үүднээс авч үздэг. Үүнийг “*Subrogation буюу төлбөр нэхэмжлэх эрх шилжүүлэлт*”-ийн онол хэмээн нэрлэдэг. Тухайн онолыг анх “Тэнгисийн даатгалын тухай хууль (1906) Marine Insurance Act”-даа зохицуулж хуульчилснаар даатгалын эрх зүйн харилцаанд албан ёсоор хэрэглэдэг болсон.²⁶

Өөрөөр хэлбэл, “*Бусдын буруутай үйлдлээс болж даатгагч хохирлыг барагдуулсан бол даатгагч нь даатгуулагчийн эрхийг өөрт шилжүүлэн авснаар буруутай этгээдээс төлсөн хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болно*” гэж эрх зүйн зохицуулалтдаа тусгасан байдаг.²⁷ Харин МУ-ын хувьд дээрх онолтой дүйцэхүйц ойлголтыг ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7-д хуульчлан зохицуулсан.

Англи улсад хувийн осол гэмтэл, нас баралттай холбоотой даатгалыг “Гэнэтийн ослын даатгал (Personal accident Insurance), Амь насны даатгал (Life Insurance)²⁸, эсхүл Төлбөр тасалдалтын даатгал (Payment Protection Insurance)²⁹ ”-д хамрагдсанаар учирсан гэм хор, хохирлыг “суброгаци”-аар дамжуулан нөхөн төлүүлэх эрх үүсдэг. *Зээлийн эрсдэлийн даатгалд бие махбодын гэмтэл, нас баралт зэрэг тохиолдлууд хамаардаггүй, харин санхүүгийн хүндрэлээс болж зээлдэгчид зээлээ төлөхгүй байх болон гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, зөрчих эрсдэлээс зээлдүүлэгчдийг хамгаалахад гол зорилго нь оршдог.*

Дээрхээс үзвэл хэдий даатгагч нь “суброгаци”-ын онолоор даатгуулагчаас нөхөн төлбөр нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авч, хүний амь насанд хохирол учруулсан гуравдагч этгээдээс нөхөн төлбөрийг гаргуулах шаардах эрхийг хэрэгжүүлж болох хэдий ч зээлийн эрсдэлийн даатгал нь зээлийн гэрээний үүргийг хангахтай холбоотой буюу гэрээний үүрэг биелэгдэхгүй байх эрсдэлийг хамардаг тул гэрээний бус үүргийн эрх зүйн харилцааны үр дагаврыг авч үздэггүй хэмээн ойлгож болно.

3.3.2. ЯПОН УЛС

Зээлийн эрсдэлийн даатгал, хамаарах төрлийн тухайд:

Япон улс нь Иргэний хууль “Civil Code (Act No. 89 of 1896) ”-даа даатгалын гэрээний төрлүүдийг тодорхой ангилах байдлаар хуульчлаагүй хэдий ч гэрээ, түүний дотор даатгалын гэрээ байгуулах эрх зүйн үндэс, талуудын эрх, үүрэг, үүрэг хариуцлага, даатгалын гэрээний биелэлтийг хангах зэрэг зохицуулалтуудыг хуульчилсан онцлогтой байдаг³⁰ бол даатгалын эрх зүйн харилцааг нарийвчилсан

²⁶ Marine Insurance Act (1906), Section 79, Subrogation, <https://www.legislation.gov.uk/ukpga/Edw7/6/41/section/79> (Сүүлд үзсэн: 2024.08.19)

²⁷ Imtithal, Babiker Ahmed, Some Aspects of the Doctrine of Subrogation in Insurance Law (2006), 9, <https://core.ac.uk/download/pdf/71675844.pdf> (Сүүлд үзсэн: 2024. 08.19)

²⁸ Critical illness and life insurance, <https://www.unbiased.co.uk/discover/insurance/critical-illness-insurance/what-is-personal-accident-insurance-and-what-does-it-cover> (Сүүлд үзсэн: 2024. 08.19)

²⁹ Danielle Courtin, Payment Protection Insurance, <https://www.i-m-a.org.uk/wp-content/uploads/ima-ljdoc-191%2020.pdf> (Сүүлд үзсэн: 2024.08.23)

³⁰ Civil Code of Japan (Act No.89 of 1896), Japanese Law Translation,

байдлаар Даатгалын тухай хууль “Insurance Act (Act No. 56 of June 6, 2008)” болон Даатгалын Бизнесийн тухай хууль “Insurance Business Act (Act No. 105 of 1995) ”-аар зохицуулдаг.

Даатгалын тухай хууль нь даатгалыг амь насны даатгал (life insurance) болон ердийн даатгал (non-life insurance) гэсэн хоёр төрөлд ангилан зохицуулдаг.³¹

Амь насны даатгал нь өвчин эмгэг тусах, хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл бий болох тохиолдолд түүнээс үүсэх санхүүгийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилготой юм.³² Харин ердийн даатгал нь осол аваар, эд хөрөнгийн хохирол, хариуцлага болон бусад амь насанд хамаарахгүй тохиолдлоос үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс сэргийлэх даатгалын нөхцөлүүдийг хамруулдаг.³³ Санхүүгийн алдагдлаас хамгаалахтай холбоотой даатгал нь ердийн даатгалд хамаардаг бөгөөд зээлийн эрсдэлийн даатгал нь мөн адил тус даатгалд хамаарах юм.³⁴

Зээлийн эрсдэлийн даатгалын хувьд даатгагчид даатгуулагчдыг зээлээ төлөхгүй байх эрсдэлээс хамгаалдаг бөгөөд энэ талаар Япон улсын Иргэний хуулийн 415 дугаар зүйлд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд “*үүрэг гүйцэтгэгч үүргийн зорилгод нийцүүлэн үүргээ биелүүлээгүй, эсхүл үүргээ биелүүлэх боломжгүй бол үүрэг гүйцэтгэгч үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардаж болно; ийнхүү үүргээ гүйцэтгээгүй нь гэрээ болон үүргийн бусад эх үүсвэр, хэлцлийн нийтлэг ойлголтын хувьд үүрэг гүйцэтгэгчид хамаарахгүй үндэслэлээс шалтгаалсан бол энэ нь хамаарахгүй болно*”³⁵ гэжээ. Өөрөөр хэлбэл, тус зүйлд даатгуулагчийн зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг тусгасан хэмээн ойлгож болно.

“Subrogation by Performance буюу үүргийн гүйцэтгэлийн эрхийг шилжүүлэх, орлуулах” болон гуравдагч этгээдийн хариуцлагын тухайд:

Тус улс нь Иргэний хуульдаа “subrogation буюу суброгаци”-ийг зарчмын үүднээс тусгаж өгсөн байдаг. Суброгаци нь даатгалын эрсдэл үүссэнээр даатгуулагчид нөхөн төлбөрийг олгосон даатгагч нь даатгуулагчийн эрхийг шилжүүлэн авсан учир тухайн хохирлын нөхөн төлбөрийн үнийн дүнг гуравдагч этгээдээс шаардах боломжийг олгодог. Тодруулбал, *даатгагч нь даатгуулагчийн хохирлыг нөхөн төлсний дараа даатгуулагчийн эрхийг шилжүүлэн авч, бусад этгээд буюу*

https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3494/en#je_pt2ch10sc2at21 (Сүүлд үзсэн: 2024.08.23)

³¹ Insurance Act (Act No. 56 of June 6, 2008), Japanese Law Translation, Chapter II, III <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2775/en> (Сүүлд үзсэн: 2024.08.25)

³² Insurance Act, *supra note*, Chapter III, Art 3, and

Insurance Business Act (Act No. 105 of 1995) , Japanese Law Translation, Art. 3(4)(i),(ii), and (iii), https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3243/en#je_pt2ch1at1 (Сүүлд үзсэн: 2024.08.27)

³³ *Ibid*, Chapter II, Art.3-Art.36.

³⁴ Insurance Act, *supra note*, Duty of Disclosure, Art.4

³⁵ Civil Code of Japan, *supra note* Art.415.

гуравдагч этгээдээс нөхөн төлбөр болох хариуцлагыг нэхэмжлэх эрхтэй болдог гэсэн үг.³⁶

Зээлийн эрсдэлийн даатгал нь зөвхөн гэрээний үүргээ зөрчсөн, зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх алдагдлыг нөхөн төлдөг ба бусад амь нас, өвчин эмгэг болох амь насны даатгалын төрөлд хамаардаггүй. Иймд даатгагч нь гэрээний бус үүрэгт хамаарах гуравдагч этгээдийн учруулсан хохирлын шаардах эрхийг зээлийн эрсдэлийн даатгалын хүрээнд шаардах эрхгүй юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Энэхүү дүн шинжилгээгээр “Зээлийн эрсдэлийн даатгалын гэрээний шаардах эрх ИХ-ийн 443.7-д заасны дагуу шилжих эсэх, тус зохицуулалтыг ИХ-ийн 497.1-тэй уялдуулан тайлбарлах асуудал” -ыг хөндөн, дүн шинжилгээ хийсэн болно.

Сонгон судалсан шүүхийн шийдвэрийн гол маргааны зүйл буюу үндсэн асуудал нь “зээлийн эрсдэлийн даатгалын гэрээний шаардах эрхээр гуравдагч этгээдийн учруулсан гэм хор, хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой эсэх” буюу “даатгагчаас эрх бүхий этгээдэд төлсөн даатгалын нөхөн төлбөрийг даатгалын эрсдэл бий болоход нөлөөлсөн гэм буруутай гуравдагч этгээдээс шаардан гаргуулах үндэслэлтэй эсэх” тухай асуудал юм.

Хяналтын шатны шүүх зээлийн эрсдэлийн даатгал нь зээлийн гэрээний үүргийг биелүүлээгүй тохиолдолд хэрэгжих эрсдэлийн даатгал гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, зээлийн гэрээний үүргийг биелүүлэхтэй холбоотой үүргийн харилцаа зонхилж байгаа тул энэхүү даатгал нь гэрээний үүргийн бус буюу гэм хорын болон амь насны даатгалд хамаарах учир ИХ-ийн 443.7-ын дагуу “гэм хорын шаардах эрхтэй”, мөн ИХ-ийн 497.1-ийн дагуу “гэм хорын эрх зүйн харилцаанд үйлчлэх, гэрээний бус үүргийн харилцаанд үүссэн гэм хор, хохирлыг хариуцан арилгах үүрэгтэй” байна.

Иймд, зээлийн гэрээний үүргийн хариуцлагыг гэрээний бус үүрэгт хэрэгжих заалтуудыг хэрэглэн, зээлийн эрсдэлийн даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжлэх хууль зүйн үндэслэл байхгүй болох нь энэхүү дүн шинжилгээний хүрээнд хийсэн судалгаанаас харагдаж байна.

Харьцуулсан судалгааны хүрээнд авч үзсэн Англи улс нь зээлийн эрсдэлийн даатгалд төлбөрийн чадваргүй болох болон гэрээний үүрэг биелэгдэхгүй байх гэсэн даатгалын эрсдэлийн суурь нөхцөлийг заадаг. Өөрөөр хэлбэл, даатгалын эрсдэл үүссэн тохиолдолд санхүүгийн хүндрэлээс болж зээлдэгчид зээлээ төлөхгүй байх болон гэрээний үүргээ зөрчих эрсдэлээс зээлдүүлэгчдийг хамгаалдаг.

Харин хувийн осол гэмтэл, нас баралттай холбоотой даатгалыг “Гэнэтийн ослын даатгал (personal accident Insurance), Амь насны даатгал (Life Insurance), эсхүл Төлбөр тасалдлын даатгал (Payment Protection Insurance)”-д хамрагдсанаар учирсан гэм хор, хохирлыг нөхөн төлүүлэх шаардах эрхээ хэрэгжүүлэх боломж үүсдэг.

³⁶ Ibid, Art.599.

Япон улсын хувьд зээлийн эрсдэлийн даатгал нь ердийн даатгалд хамаардаг. Харин аливаа бэртэл гэмтэл, нас баралт, осол, өвчин эмгэгээс үүдэлтэй хохирлын даатгалын нөхөн төлбөрийг гуравдагч этгээдээс шаардах эрх нь амь насны даатгалд хамаарч байх тул зээлийн эрсдэлийн даатгалын нөхөн төлбөрийг амь насны даатгалд хамааруулан амь насны даатгалын гэрээний шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжгүй байдаг байна.

Иймд, зээлийн эрсдэлийн даатгал нь зөвхөн гэрээний үүргээ зөрчсөн, зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх алдагдлыг нөхөн төлдөг байх бөгөөд бусад амь нас, өвчин эмгэг болох амь насны даатгалын төрөлд хамаардаггүй байна.

Харин Монгол Улсын дээд шүүхийн 001/ХТ2024/00126 дугаар бүхий тогтоолоор ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 443 дугаар зүйлийн 443.7 дэх хэсгүүдийг зээлийн эрсдэлийн даатгалын хүрээнд тайлбарлахдаа: “зээлийн эрсдэлийн даатгал нь зээлдэгч нас барж, түүний бусдад өгөх зээл төлөгдөхгүй болох эрсдэл нь гэм хорын төрөл биш, харин зээлийн гэрээний үүрэг биелэгдэхгүй байх эрсдэлийг хамардаг тул гэмт хэргийн улмаас хохирогч нас барснаар гэм буруутай этгээдээс шаардан нэхэмжлэх гэм хорын төрөлд хохирогчийн бусадтай байгуулсан зээлийн гэрээний төлөгдөөгүй үлдэгдэл хамаарахгүй” гэх дүгнэлт нь харьцуулсан улсууд дахь онол, практиктай адил агуулгатайгаар дүгнэж, хуулийн зүйл заалтыг хэрэглэсэн байна.

НОМ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Иргэний хууль (2002)
2. Marine Insurance Act (1906).
3. Civil Code of Japan (Act No.89 of 1896).
4. Insurance Act (Act No. 56 of June 6, 2008).
5. Insurance Business Act (Act No. 105 of 1995)

Монгол хэл дээрх эх сурвалж

1. Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн тусгай анги: гэрээний эрх зүй*, 5 дах хэвлэл, 2019.
2. Ж.Оюунтунгалаг, *Иргэний эрх зүй II, Гэрээний үүрэг*, 2022.
3. Монгол Улсын Дээд шүүх, *Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Гэрээний бус үүрэг IV*, 2016.
4. Санхүүгийн зохицуулах хороо, *Үл хөдлөх эд хөрөнгийн даатгалын гарын авлага* (2014), УБ хот

Цахим болон гадаад хэл дээрх эх сурвалж

1. Монгол даатгал, *Зээлийн эрсдэлийн даатгал*, https://www.mongolmaatgal.mn/?page_id=6642

2. Монгол банк, Санхүүгийн боловсрол, даатгал, түүний төрлүүд, <https://www.sankhuuginbolovsrol.mn/cdn/pdf/Huvi%20hun%20buleg14.pdf>
3. Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын үүсэл хөгжил, хэтийн төлөв судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан, https://nli.gov.mn/pdf/gadaadiin_hurungu_oruulaltiin.pdf
4. James Larkin, *Credit Insurance-An Introduction* (1995), <https://bila.org.uk/wp-content/uploads/old/4ff4163fdbaa93.57092984.pdf>.
5. Aon Credit International (ACI), *Introduction to Credit Insurance* (2016), <https://www.aon.com/unitedkingdom/products-and-services/risk-services/attachments/aci/aci-introduction-credit-insurance.pdf>.
6. Imtithal, Babiker Ahmed, *Some Aspects of the Doctrine of Subrogation in Insurance Law* (2006), <https://core.ac.uk/download/pdf/71675844.pdf>.
7. Critical illness and life insurance, <https://www.unbiased.co.uk/discover/insurance/critical-illness-insurance/what-is-personal-accident-insurance-and-what-does-it-cover>.
8. Danielle Courtin, *Payment Protection Insurance*, <https://www.i-m-a.org.uk/wp-content/uploads/ima-ljdoc-191%2020.pdf> .

Шүүхийн шийдвэр

1. Монгол Улсын Дээд шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 001/ХТ2024/00126 дугаар тогтоол.
2. Монгол Улсын Дээд шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 001/ХТ2018/00604 дугаар тогтоол.

---o0o---